

## БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХОС ХЭЛНИЙ ТҮВШНИЙГ ТОГТООХ СУДАЛГАА, ҮР ДҮН

Харий Сандугаш<sup>1</sup>, Жамсрандорж Батдэлгэр<sup>2</sup>

<sup>1</sup> Боловсролын Ерөнхий газар

<sup>2</sup> Монгол Улсын Боловсролын Их Сургууль

### Өгүүллийн мэдээлэл

#### Түүх:

Хүлээн авсан: 2024.02.04

Засаж сайжруулсан: 2024.02.18

Хэвлэхийг зөвшөөрсөн: 2024.02.19

#### Түлхүүр үг:

Хэл, хос хэл, ойлгох чадвар, ярих чадвар, хэл яриа, TEDL-3 сорил

#### Холбоо барих зохиогч:

Х.Сандугаш

Email: khsandugash@gmail.com

### Хураангуй

Монгол Улсад ялгаатай хэл, соёлтой сургуулийн өмнөх насны хүүхдийг хос хэлээр (казах, монгол) хөгжүүлэх сургалт явагдахгүй, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх шийдэл нь тодорхой бус байгаа нь чухал асуудал болоод байна. Эл асуудлын үндэс нь хүүхдэд өөрийн хэл, соёлоо сурах хэрэгцээ байдаг бол нөгөөтэйгүүр сургуульд элсэн ороод цаашид боловсрол эзэмших гол хэрэгслийн нэг нь хэл юм. Хүүхэд эх хэлээрээ сурахаас гадна хоёрдогч хэлийг эзэмших нь тэдний хөгжил, боловсролд төдийгүй, тэгш хамруулах боловсролын зарчмыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй юм. Энэхүү өгүүллийн зорилго нь 4-5 насны хос хэлтэй (казах, монгол) хүүхдийн ойлгох, ярих чадварын төлөв байдлыг илрүүлж, хөгжлийн түвшнийг тогтооход чиглэсэн юм. Байдлыг тогтоох судалгаанд Америкийн эрдэмтэд Уэйн П.Хреско, Д.Ким Рейд, Дональд Д.Хэммилл нарын боловсруулсан “Бага насны хүүхдийн хэл ярианы хөгжлийг илрүүлэх” TELD-3 (Test of Early Language Development) аргазүй болон ганцаарчилсан ярилцлагын аргыг ашигласан. Байдлыг тогтоох судалгаанд Улаанбаатар хотын бүсийн төлөөлөл болох цэцэрлэгт хамрагдаж байгаа 4-5 настай казах, монгол хос хэлтэй 120 хүүхдийг, Баян-Өлгий аймгийн цэцэрлэгүүдээс 30 хүүхдийг хамруулсан. Судалгааны үр дүнд хүүхдүүдийн оршин суугаа орон нутгаас хамааран казах, монгол хэлний хэрэглээ өөр өөр байгаа нь хүүхдийн хэл ярианы хөгжилд яаж нөлөөлж байгааг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ байгааг харууллаа. Судалгааны сорилын статистик үзүүлэлт нь хүүхдийн ойлгох чадвар, ярих чадварын хувьсагч нь орчны хэлний байдал, сургалтын хэл, гэрийн хэлний орчноос шууд хамааралтай байгааг тогтоолоо.

### RESEARCH AND RESULTS OF DETERMINING THE LEVEL OF BILINGUALITY OF YOUNG CHILDREN

#### Authors

Kh.Sandugash<sup>1</sup>

<sup>1</sup>General Authority for Education

J.Batdelger<sup>2</sup>

Mongolian National University of  
Education

### Abstract

An important problem is that there is no bilingual (Kazakh and Mongolian) training for pre-school children with different languages and cultures in Mongolia, and the solution of how to implement it is not clear. The root of the problem is that children need to learn their native language and culture, and on the other hand, language is one of the main tools for further education after entering school. In addition to learning a child's mother tongue, mastering a second language is important not only for

**Keywords:** Language, bilingualism, comprehension, speaking, language, TEDL-3 test

their development and education, but also for the implementation of the principle of inclusive education. The purpose of this article is to identify the state of understanding and speaking ability of 4-5 year old bilingual (Kazakh, Mongolian) children and determine the level of development. In the survey, American scientists Wayne P. Hresco, D. Kim Reid, and Donald D. Hammill used the TELD-3 (Test of Early Language Development) method and the individual interview method. 120 4-5-year-old bilingual children attending kindergartens in Ulaanbaatar city and 30 children from kindergartens in Bayan-Olgii province were included in the survey. The results of the research show that there is a need for in-depth study of how the use of Kazakh and Mongolian languages is different depending on the region where the children live. The statistical indicators of the research test revealed that the variables of children's comprehension and speaking ability are directly related to the language of the environment, the language of instruction, and the environment of the home language.

## УДИРТГАЛ

Хүүхэд цэцэрлэгт орохдоо гэртээ ярьдаг хэлээсээ өөр хэлний орчинд орох нь түүний өөртөө итгэх итгэл, сэтгэл хөдлөл, өөрийнхөө бодол санааг илэрхийлэх, бусдыг ойлгох, бусадтай харилцах харилцаанд хүндрэл, бэрхшээл учирдаг. Ийм бэрхшээл манай улсын Баян-Өлгийгөөс бусад аймаг, сумдад амьдардаг казах хүүхдүүдэд тохиолдож байгаа бодит байдал юм. Энэ тухай МУИС-ийн Европ судлалын тэнхимийн профессор, доктор Б.Алтангүлийн “Хот, суурин газар амьдарч буй казах иргэдийн эх хэлний хэрэглээ болон хүний эрх” сэдэвт өгүүлэлд дурджээ.

Олон улсад хүүхдийн эх хэл дээр суурилсан хос хэл, олон хэлээр боловсрол олгох хөтөлбөрийг сургуулийн өмнөх наснаас амжилттай хэрэгжүүлж буй туршлага байна. (Эрдэм шинжилгээний бичиг, 2019, 23 дугаар тал) Аль ч улсын үндэстний цөөнхийн хүүхдүүд эх хэлнээс гадна төрийн албан ёсны хэлийг эзэмших эрх, хэрэгцээ байдаг. Өөрийн хэл соёлыг хадгалах, өвлүүлэх нь эдгээр хүүхдийн хувь хүний суурь эрх болдог бол төрийн албан ёсны хэлийг эзэмших нь үндэстний цөөнхийн хүүхдүүдэд өргөн хүрээтэй нийгмийн харилцаанд оролцох, боловсролыг хүссэн газраа тасралтгүй эзэмших, бодит нөхцөл тул мөн л эдгээр хүүхдийн нийгэм, эдийн засаг, хүний эрхийн асуудал болдог (Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд судалгааны тайлан, 2020, 36-38 тал).

Хэл бол зөвхөн харилцаа, мэдээллийн хэрэгсэл биш, хувь хүн болон соёлын бүлгийн хувьд өөрсдийн амин чанарыг бэхжүүлэх үндэс юм (ЮНЕСКО, 2008). Тиймээс ч үндэстний цөөнхийн хүүхдүүд хоёр хэлээр боловсрол эзэмших онцлог хэрэгцээтэйг хүлээн зөвшөөрч, улс орнууд бага болон суурь боловсролд хос хэлний боловсролын стандарт, сургалтын арга зүйг нэвтрүүлдэг.

Сургуулийн өмнөх насны хүүхдийг (үндэсний цөөнхийн) хос хэлээр (казах, монгол) хөгжүүлэх сургалт явагдахгүй байгаа төдийгүй түүнийг хэрхэн яаж нэвтрүүлэх вэ гэдэгт дидактик шийдэл тодорхой бус байгаа нь асуудал байна. Иймд үндэсний цөөнхийн сургуулийн өмнөх насны хүүхдийн хэл ярианы одоогийн нөхцөл байдлыг тогтоох судалгаа хийх хэрэгцээ үүсэж байгаа юм.

## СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

“Сургуулийн өмнөх насны хүүхдийн хоёр ба олон хэл сурах онцлог” сэдэвт судалгааг Турк Улсын Акдениз Их сургуулийн сургуулийн өмнөх боловсролын салбарын багш доктор, профессор Зелиха Языжы болон тус сургуулийн гадаад хэлний тэнхимийн багш доктор Биннур Генч нар 2008 онд хийжээ. Уг судалгаанд бага насны хүүхдийг төрсөн цагаас эхлэн хос хэлээр хөгжүүлэх, 3-6 насны хүүхдэд хоёрдогч хэл заах нь үр дүнтэй хэмээн үзсэн байна. Учир нь хүүхдийн нас бага байх тусам тархинд шинэ холбоос олноор үүсэх боломж өндөр, хос хэл эзэмших явц нэг хэл эзэмших үйл явцтай ижил тул хүүхэд уг чадварыг хүлээн авч, эзэмших боломжтой байдгийг тэмдэглэжээ (Ч.Чулуун-Эрдэнэ, 2015, 65 дугаар тал).

Румин улсын Димитри Кантемирийн их сургуулийн судлаач Анка Нэмеш Адела Морару нар 1997 онд “Сургуулийн өмнөх насны хүүхдийн хэл ярианы хөглийн судалгаа”-г онд хийжээ. Тэд судалгаандаа сургуулийн өмнөх насны хос хэлтэн 40 хүүхдийн (5-7 нас) хэл ярианы чадварын ялгааг авиа зүй болон үгийн сангийн хүрээнд судалжээ. Тус судалгаагаар Р.Брауны “Хэл бол дурын тэмдэгтийн систем гэж тодорхойлсон”-ыг үндэслэн, бага насны хүүхдийн хос хэлтэй байхын давуу болон сул тал, онцлогийн талаарх маргаанд үндэслэсэн дараах дүгнэлтийг хийжээ. Тэрээр “Үг нь үйл явдал, юмсыг орлодог тэмдэгт бөгөөд хүүхэд тэмдэгт, үйл явдал хоёрын хоорондын уялдаа холбоог сурах явцад хэлийг эзэмшдэг. Хэлийг чадварлаг хэрэглэгч болохын тулд хүүхдийн зөвхөн үгсийн сан арвин байх төдийгүй хүүхэд дүрмийн мэдлэгтэй байх хэрэгтэй (R.Brown, 1997).

Хэдийгээр зарим судлаачид бага насны хүүхэд хос хэлтэй байх нь хүүхдийн танин мэдэхүйн хөгжилд сөргөөр нөлөөлдөг гэсэн дүгнэлт гаргаж байсан ч сүүлийн үеийн судалгаагаар хүүхэд хос хэлээр хөгжих явцад эх хэлний хэл ярианы хөгжилтэй холбоогүй, ялангуяа нэг хэл нь нөгөө хэлийг дарангуйлах шинжтэй байдаг гэсэн сөрөг дүгнэлтүүдийг няцааж, харин ч хос хэлтэн байх нь хүний танин мэдэхүйн чадварыг сайжруулж байгааг харуулж байна. Тэнцвэртэй хос хэлтэй буюу чөлөөтэй ярьдаг хүүхдүүдийн авиа зүй болон үгийн сангийн мэдлэг нь хоёр хэл дээр ижил түвшинд байгааг тогтоосон байна. Хүүхдүүдийн нэг хэлний үгийн сангийн хувьд зарим сэдвийн хүрээнд хоёр хэл дээр бага зэрэг ялгаатай ч, хоёр хэлний бүх авиаг дуудаж чаддаг болохыг нотолсон байна (Dilbilim araştırmaları dergisi №3, 47-61 дугаар тал, 2008).

Манай улсын хувьд хос хэлний сургалтын талаар дараах судалгаа хийгджээ. Боловсролын хүрээлэнгийн үндэстний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны сектороос 2014 онд “Хос хэлээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын эх хэлний түвшнийг тандах судалгаа”, 2015 онд “Хос хэлээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын монгол хэлний түвшнийг тандах судалгаа”-г тус тус хийжээ. Энэ судалгааны үр дүнгээс харахад казах хүүхдүүд сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд казах хэлээр боловсролын үйлчилгээнд хамрагддаг ба 2 дугаар ангиасаа монгол хэлний хичээлийг судалж эхэлдэг. Зургаадугаар ангиас эхлээд казах хэлний хичээлээс бусад бүх хичээл нь монгол хэлээр ордог энэ байдал нь асуудлыг дагуулж байна. Учир нь эдгээр хүүхэд монгол хэлний үгийн нөөц хангалтгүйгээс сурлагын хоцрогдолд орох магадлал өндөр байгааг илрүүлжээ (Боловсролын хүрээлэн, 2015). Хос хэлтэй орчинд хэлний хэрэглээнд дүн шинжилгээ өгөх гол хэрэглүүр нь хэлний хэрэглээний хүрээ ба энэ нь хэл хоорондын үнэ цэнтэй, ялгаатай байдлыг илэрхийлэх гол хүчин зүйлд тооцогдох болсон (Боловсролын хүрээлэн, 2013).

## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Судалгааны зорилго нь 4-5 настай үндэсний цөөнхийн хүүхдийн хос хэлээр (казах, монгол) ойлгох, ярих чадварын өнөөгийн нөхцөл, байдлыг тогтоож, үр дүнг тооцоход оршино.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Хүүхдийн хос хэлний хэл ярианы хөгжлийг илрүүлэх судалгаанд Америкийн эрдэмтэд Уэйн П.Хреско, Д.Ким Рейд, Дональд Д.Хэммилл нарын боловсруулсан Test of Early Language Development (TELD-3) сорилыг ашигласан. Анх 1981 онд 3-аас 7 нас 11 сартай хүүхдийн хэл ярианы хөгжлийн төлөв байдлыг илрүүлэх зорилгоор боловсруулсан байна. 1991 онд сайжруулж, 2-оос 7 нас 11 сартай хүүхдүүдэд зориулан TELD-2 нэрээр хэвлүүлсэн байна. 1999 онд TELD-2 сорилоор хийгдсэн судалгааны үр дүнд үндэслэн ашиглах зургуудыг нь өнгөтөөр хэвлэн, асуултуудыг ойлгох болон ярих чадварыг илрүүлэх зорилгоор нь хоёр хэсэгт хувааж, шинээр стандарт оноог боловсруулан TELD-3 нэрээр шинэчлэн хэвлэсэн. Энэхүү аргазүйг Турк улсын Анадолы Их сургуулийн судалгааны төвийн судлаачид Сейхан Топбаш, Селчук Гүвен нар 2013 онд турк хэлээр хэвлүүлсэн байна. Бид тестийг турк хэлнээс монгол, казах хэл руу хөрвүүлэн, 25 хүүхдэд туршиж, зарим өгүүлбэр, зургийг монгол хүүхдийн онцлогт нийцүүлэн тохиргоо өөрчлөлтийг хийсэн. Түүний дараа судалгаанд ашигласан.

Уг сорилын аргазүй нь хүүхдийн ойлгох, ярих чадварыг илрүүлэх нийтдээ 70 асуултаас бүрдсэн бөгөөд асуултын хариу бүрд тохирох оноотой. Хүүхдийн ойлгох чадварыг асуусан асуултын дагуу зураг харж зөв хувилбарыг гараараа заах, асуултад “Тийм”, “Үгүй”, “Мөн”, “Биш” гэсэн үгсээр хариулах, хариултаа биеийн хэлэмжээр илэрхийлэх үзүүлэлтүүдээр үнэлнэ. Ярих чадварыг зураг харж юмсыг нэрлэх, асуултад үгээр хариулах, асуултад бүтэн өгүүлбэрээр хариулах, сонссон зүйлээ давтаж хэлэх үзүүлэлтүүдээр үнэлнэ.

Сорил авах хугацаа хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогоос хамааран 15-30 минут үргэлжилнэ. Сорилын хуудсанд аль асуултаас эхлэхийг чиглүүлэх зорилгоор хүүхдийн насыг тэмдэглэсэн байдаг. Хүүхдийн насанд тохирсон сорилоос эхлэн зөв хариулсан асуултад 1 (нэг) оноо, буруу хариулсан тохиолдолд 0 (тэг) оноо өгнө. Хүүхэд дараалан 3 (гурван) асуултад буруу хариулбал сорилыг зогсоож анх эхэлж асуусан асуултаас өмнөх асуултуудыг асууж гурван удаа 1 (нэг) оноо авах хүртэл үргэлжлүүлнэ. Жишээ нь 3 настай хүүхэд 10 дугаар асуултаас эхэлнэ. Хүүхэд 10, 11 дүгээр асуултад зөв хариулаад, харин 12, 13 дугаар асуултад 0 (тэг) оноо аваад 14 дэх асуултад 1 (нэг) оноо авбал цаашаа үргэлжлүүлнэ. Харин дараалан 3 асуултад хариу үйлдэл үзүүлэлгүй эсвэл буруу хариулж 0 (тэг) оноо авбал 9 дүгээр асуултаас эхлэн 8, 7, 6 гэх дарааллаар асууж гурван удаа дараалан 1 (нэг) оноо авах хүртэл үргэлжлүүлнэ. ТЕЛД-3 сорилын хувьд 1. ойлгох чадварын стандарт оноо, 2. ярих чадварын стандарт оноо, 3. ойлгох чадвар болон ярих чадварын онооны нийлбэр болох хэл ярианы хөгжлийн нийт оноо мөн 4. тохирох түвшин гэсэн нийт дөрвөн үзүүлэлтийг тооцож тухайн хүүхдийн хэл ярианы хөгжлийн түвшнийг илрүүлнэ. ТЕЛД-3 сорилын ойлгох, ярих чадварын стандарт оноо болон хэл ярианы нийт оноо, тохирох түвшнийг Guilford ба Frucher (1978) нар варианс нэгтгэх аргаар боловсруулсан байна.

### *Хүснэгт 1. Ойлгох чадвар болон ярих чадварын стандарт онооны түвшин*

| Стандарт оноо | Үнэлгээ  | Хэл ярианы хөгжлийн түвшин |
|---------------|----------|----------------------------|
| 131-165       | Маш сайн | 6                          |
| 121-130       | Сайн     | 5                          |

|         |                      |   |
|---------|----------------------|---|
| 111-120 | Дундаас дээш         | 4 |
| 90-110  | Дунд                 | 3 |
| 80-89   | Дундаас доош         | 2 |
| 35-79   | Дэмжлэг шаардлагатай | 1 |

Сорилыг нэг хэлээс нөгөө хэлэнд хөрвүүлэн ашиглах нь дахин сорил болон аргагүй боловсруулахаас эдийн засгийн хувьд хэмнэлттэй. Хэрэв хоёр хэл хоорондын харьцуулсан судалгаа явуулах бол нэгдүгээр хэлээр эхний хувилбарыг, хоёр дахь хэлээр дараагийнх нь хувилбарыг ашиглах нь хамгийн тохиромжтой (Seyhan TOPBAŞ ve Selçuk GÜVEN, 2013).

Бид судалгаандаа баримт бичгийн шинжилгээ, TELD-3 сорилын гүйцэтгэлийн шинжилгээ, чанарын ярилцлагын аргуудыг ашиглаж, үр дүнд статистик боловсруулалт хийсэн. Хүүхдийн казах хэлний түвшнийг илрүүлэхэд TELD-3 сорилын А хувилбарыг, монгол хэлний хэлний түвшнийг илрүүлэхэд сорилын В хувилбарыг ашигласан. Сорил нь хүүхдийн ойлгох болон ярих чадварыг илрүүлэх хэсэгтэй бөгөөд тус хоёр хэсгийн онооны нийлбэрээр хүүхдийн хэл ярианы түвшнийг илрүүлэх стандарт оноог тооцох аргачлалтай. TELD-3 сорилын зурган сорилын хуудаснууд нэг талдаа А хувилбарын тестийн зурагтай, нөгөө талдаа В хувилбарын тестийн зурагтай болно. Зургууд нь үсэг болон тоогоор кодлогдсон. Сорилын аль хувилбар дээр аль зургийг ашиглахыг тухайн кодоор нь тэмдэглэсэн байдаг.

Хүүхдийн ойлгох болон ярих чадварыг TELD-3 үнэлгээний аргачлалаар стандарт оноонд хувиргаж 4-5 настай хүүхдийн хэл ярианы түвшнийг илрүүлнэ.

*Хүснэгт 2. Судалгаанд оролцогчдын түүврийн байршил.*

| № | Байршил               | Цэцэрлэгийн тоо | Бүлгийн тоо | Хүүхдийн тоо |
|---|-----------------------|-----------------|-------------|--------------|
| 1 | Баянгол дүүрэг        | 2               | 3           | 13           |
| 2 | Баянзүрх дүүрэг       | 4               | 6           | 23           |
| 3 | Сүхбаатар дүүрэг      | 2               | 3           | 10           |
| 4 | Сонгинохайрхан дүүрэг | 2               | 4           | 12           |
| 5 | Налайх дүүрэг         | 4               | 9           | 38           |
| 6 | Чингэлтэй дүүрэг      | 3               | 3           | 11           |
| 7 | Хан-Уул               | 5               | 6           | 13           |
| 8 | Баян-Өлгий аймаг      | 3               | 5           | 30           |
|   | Нийт                  | 25              | 39          | 150          |


## СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Дэвшүүлсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд бид 2022 оны 9 дүгээр сарын 5-аас 9 дүгээр сарын 25 хүртэлх хугацаанд судалгааны мэдээлэл цуглуулсан. Судалгаанд нийт 150 хүүхэд хамрагдсан. Хүүхдийн ойлгох чадварыг илрүүлэх сорил нь асуусан асуултын дагуу зураг харж зөв хувилбарыг гараараа заах 13, багшийн асуултад “Тийм”, “Үгүй”, “Мөн”, “Биш” гэсэн үгсээр хариулах 5, хариултаа биеийн хэлэмжээр илэрхийлэх 6, хэлж өгсөн үйл явдлын товч утгыг ойлгож байгааг тандах 4 нийт 27 даалгавраас бүтсэн ба үүнээс хамгийн олон хүүхдийн зөв гүйцэтгэж чадсан сорил нь “Зураг харж зөв хувилбарыг гараараа заах” даалгавар байсан. Ярих чадварыг дараах үзүүлэлтүүдээр үнэлсэн бөгөөд эдгээр нь зураг харж, юмсыг нэрлэх сорил 10, асуултад үгээр хариулах сорил 6, асуултад өгүүлбэрээр

хариулах сорил 7, сонссон зүйлээ давтаж хэлэх сорил 2, сонссон зүйлээ дүгнэж ярих сорил 2 гэсэн нийт 27 асуулттай юм.

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 52 хувийг хөвгүүд, 48 хувийг охид эзэлж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дундаж нас нь 4 нас 8 сартай, хамгийн бага нь 4 нас 1 сартай, хамгийн ахмад нь 5 нас 6 сартай байна. Ихэнх хүүхэд 4 нас 6 сартай байна. Бид TELD-3 аргачлалын дагуу эхлээд судалгаанд хамрагдсан нийт хүүхдүүдийн хос хэлээр ойлгох, ярих чадварын оноонд үндэслэн тэдний хос хэлний түвшнийг тооцож үзлээ. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийг амьдарч байгаа газраас нь хамаараад хэлний чадвар нь ямар байгааг тус тус тооцож үр дүнг нэгтгэв. Энэхүү харьцуулалтын үр дүнг авч үзвэл.

Зураг 2. Байдлыг тогтоох судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хос хэлний түвшний үзүүлэлт (хувиар)



Зургаас харахад, судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн монгол хэлний түвшнийг хамгийн өндөр хувиас буурах дарааллаар эрэмбэлбэл, 46.6 хувь нь дундаас дээш, 21.9 дэмжлэг шаардлагатай байгаа бол 1.30 хувь дундаас доош түвшинд байна. Харин казах хэлээр ойлгох, ярих чадварыг авч үзвэл 23.3 хувь нь дундаас дээш түвшинд байгаа бол 35.9 хувь нь дэмжлэг шаардлагатай түвшинд байна. Эндээс харахад судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн казах хэлний түвшин нь монгол хэлнээс доогуур байна. Энэ нь судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн дийлэнх нь Улаанбаатар хотоос оролцсонтой холбоотой, өөрөөр хэлбэл, хүүхдүүдийн оршин суугаа байршлаас хамааран казах, монгол хэлний хэрэглээ өөр өөр байгаа нь харагдаж байна. Цаашид хүүхдийн оршин суугаа байршил нь хүүхдийн хэл ярианы хөгжилд хэрхэн нөлөөлж байгааг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ байгааг харууллаа.

Зураг 3. Баян-Өлгий аймгийн хүүхдүүдийн казах хэлний түвшний үзүүлэлт. N=30 (хувиар)



Баян-Өлгий аймгаас оролцсон хүүхдүүдийн казах хэлний түвшнийг авч үзэхэд 28 хувь нь сайн, 45 хувь нь дундаас дээш, 17 хувь нь маш сайн, 7 хувь нь дундаас доош түвшинд байна. Энэ нь тухайн орон нутагт хүүхдүүд гэртээ ярьдаг хэлээрээ сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байгаатай холбоотой юм. Эх хэл дээр нь суурилж сургалт явагдаж байгаа нь хүүхдийн хэл ярианы хөгжилд сайнаар нөлөөлж байгааг илтгэж болох юм.


Улаанбаатар хотын хүүхдүүдийн хос хэлээр ойлгох, ярих чадварыг илрүүлэх сорилын үр дүнг тооцож, хэл ярианы хөгжийн түвшнийг тооцож үзэхэд дараах үр дүн гарсан.

Зураг 4. Улаанбаатар хотын хүүхдүүдийн казах хэлний түвшин  $N=120$  (хувиар)



Зургаас харахад дийлэнх хүүхдүүдийн казах хэлний түвшин дэмжлэг шаардлагатай гэсэн үзүүлэлттэй байгаа бол 21 хувь нь дундаас доош түвшинд байна. Хүүхдүүдийн 22 хувь нь дунд түвшинд байгаа нь ихэнх хүүхдүүд хэлд орохдоо казах хэлээр ороод гэр бүлийн орчинд казах хэлээр ярьдагтай холбоотой юм. Учир нь монгол хэлээр үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэгт хамрагддаг, амьдарч байгаа орчин, эргэн тойрон нь монгол хэлээр хүрээлэгдсэн байгаа ч казах хэлний түвшин нь дундаж түвшинд байгаа хүүхдүүд олон байна. Харин зураг 3 буюу Баян-Өлгий аймгийн хүүхдүүдтэй харьцуулахад казах хэлний түвшин нь доогуур байгаа нь сургуулийн өмнөх боловсролд монгол хэлээр хамрагдаж байгаатай холбоотой.

Зураг 5. Улаанбаатар хотын хүүхдүүдийн монгол хэлний түвшний үзүүлэлт  $N = 120$  (хувиар)



Судалгаанаас харахад, монгол хэлний хувьд 5.0 хувь нь маш сайн, 20.0 хувь нь сайн, 60.0 хувь нь дундаас дээш, 3.0 хувь нь дундаас доош түвшинд байна. Эдгээр хүүхэд Улаанбаатар хотод амьдардаг учраас цэцэрлэгт сургалт хүмүүжлийн бүхий үйл ажиллагаа нь монгол хэл

дээр явагддаг бөгөөд тэд сургуульд элсэн орохдоо монгол хэлийг мэдэж орох зайлшгүй хэрэгцээ байдаг бөгөөд энэ нь тэдний монгол хэлний хөгжилд сайнаар нөлөөлж байгааг 60.0 хувийн дундаас дээш түвшний үзүүлэлтээс харж болно.

## САНАЛ

Судалгааны дүн шинжилгээнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. ТЕЛД сорилоор бага насны хүүхдийн хос хэлний түвшинг илрүүлсний дараа хос хэлээр хөгжүүлэх арга зүйг судлан сургах туршилт зохион байгуулах хэрэгцээ байна. Хос хэлээр хөгжүүлэх сургах туршилтыг зохин байгуулсны үндсэн дээр сургалтын дараа сургалтад хамрагдсан хүүхдүүдийн хос хэлний түвшнийг анхны түвшинтэй нь харьцуулж болно.

Мөн энэхүү арга зүй нь хос хэлээр сургалт явуулдаг сургуулиудад элсэн орох хүүхдүүдийн хос хэлээр суралцахад бэлтгэгдсэн байдлыг тандсан судалгаа хийхэд ашиглах нь тохиромжтой. Бичиг үсэг тайлагдаж эхлэхээс өмөн ярианы хэлд суралцаж, тодорхой хүрээнд үгийн нөөцтэй байх нь хүүхдийн хос хэлээр хөгжих суурь болно гэж үзэж байна. Хүүхдийн хоёрдогч хэлээр уншиж, бичиж сурахад тухайн хэлний үгийн нөөц болон хэл зүйн анхан шатны мэдлэгийн түвшинг тогтоож тохирсон арга зүйгээр сургалтын үйл ажиллагааг төлөвлөх нь чухал юм.

## ДҮГНЭЛТ

Монгол улсад сүүлийн жилүүдэд үндэсний цөөнхийн хүүхдүүдийн хос хэлний талаар төрөөс анхаарч байгаа ч төвийн бүсэд амьдарч байгаа хүүхдүүдийн эх хэлээрээ сурч, хөгжих чиглэлээр сургалт, судалгааны ажил хангалттай хийгдээгүй байна. Судалгаанд хамрагдсан 4-5 настай хүүхдийн хос хэлний түвшнийг судалж үзэхэд нийт хүүхдүүдээс казах хэлний түвшнийг дэмжих шаардлагатай нь 35.9 хувийг, монгол хэлний хэл түвшнийг нь дэмжих шаардлагатай нь 21.9 хувийг эзэлж байна.

Баян-Өлгий аймгаас оролцсон хүүхдүүдийн хувьд эх хэл дээр нь суурильж сургалт явагдаж байгаа нь хүүхдийн эх хэлний хөгжилд сайнаар нөлөөлж байгааг илтгэж байна. Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн оршин суугаа орон нутгаас хамааран казах, монгол хэлний хэрэглээ өөр өөр байгаа нь хүүхдийн хэл ярианы хөгжилд яаж нөлөөлж байгааг гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ байна.

Казах хэлээр ярих чадвар нь дунд түвшинтэй байсан хүүхдүүдийн ойлгох чадвар нь сайн байсан. Монгол хэлээр ойлгох чадвар нь дэмжих шаардлагатай байсан хүүхдүүдийн ойлгох чадварыг нь ч дэмжих шаардлагатай байна. Үүнээс үзэхэд хүүхдийн эхлээд ойлгох чадвар нь хөгжөөд дараа нь ярих чадвар нь хөгждөг болох нь харагдаж байна.

Монгол хэлээр үйл ажиллагаа явуулдаг цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдүүдийн хувьд монгол хэлээр ярих чадвар нь сайн байна. Ойлгох чадварын хувьд хүүхдүүдийн дийлэнх нь зураг харж зөв хувилбарыг гараараа заах даалгаврыг сайн гүйцэтгэсэн бол ярих чадварын хувьд зураг харж нэрлэх даалгаврыг сайн гүйцэтгэсэн байна. Хүүхдүүдийн дийлэнх нь зураг харж нэрлэх даалгавар болон нэг үгээр хариулах даалгаврыг сайн гүйцэтгэсэн байна. Хамгийн олон хүүхэд алдсан даалгавар бол сонссон зүйлээ дүгнэж ярих даалгавар байсан.

Байдлыг тогтоох судалгааны сорилын статистик үзүүлэлт нь хүүхдийн ойлгох чадвар, ярих чадварын хувьсагч нь орчны хэлний хэрэглээ, сургалтын хэл, гэрийн хэлний орчноос шууд хамааралтай байна. Энэхүү судалгаагаар хүүхдийн өдөр тутмын амьдралд ашиглаж байгаа хэл нь хос хэлнээс аль нэг хэлний хөгжил давамгайл аль нэг хэлний хөгжил сул байгаа үндсэн шалтгаан болж байгаа нь харагдлаа. Улаанбаатар хотоос судалгаанд хамрагдсан 4-5 настай дийлэнх хүүхдүүдийн казах хэлээр ойлгох, ярих чадвар сул байгаа



нь тэдний казах хэлээр ойлгох, ярих чадварыг хөгжүүлэх шаардлагатай байгааг илэрхийлж байна.

47

## НОМ ЗҮЙ

TrEB, *Dilbilim arařtirmalari dergisi* (2008) Ankara, Sayfa no 3, 47-61.

*Journal of Speech-Language Pathology and Audiology* (1997). December, 17-23.

Seyhan TOPBAŞ ve Selçuk GÜVEN. (2013). *TELD-3 Kullanım Klavuzu*, Detay Yayıncılık. Ankara.

UNESCO. (2008). *Teacher Policy Development Guide*. UNESCO.

Боловсролын хүрээлэн. (2013). *Хос хэлээр сургалт явуулдаг ЕБС-ийн бага ангийн эх хэл (казах, тува)-ний сургалтын үр дүнг тандах судалгааны тайлан*. Улаанбаатар.

Боловсролын хүрээлэн. (2015). *Хос хэлээр сургалт явуулдаг ЕБС-ийн бага боловсролын монгол хэлний түвшнийг тандах судалгааны тайлан*. Улаанбаатар.

Боловсролын хүрээлэн. (2019). *Эрдэм шинжилгээний бичиг*. Дугаар 24. Улаанбаатар.

Бүх нийт боловсролын төлөө ИНБ. (2020). *Тодорхой бүлгийн хүүхдүүдэд боловсрол эзэмшихэд тулгардаг саад тотгорууд судалгааны тайлан*. Улаанбаатар.

Г.Чулуун-Эрдэнэ. (2015). *Монгол улс дахь хос хэлний нөхцөл байдлыг нийгэм хэл шинжлэлийн үүднээс судалсан судалгааны тайлан*, Улаанбаатар.